

2002 оны мөнгө, санхүүгийн бодлогын үр дүн

Бараа үйлчилгээний үнэ ханш тогтвортой байж санхүү банкны салбарын зуучлал бүх чиглэлээр гүнзгийрч, банкуудаас олон шинэ санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэн эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөө үзүүлсэн зэрэг нь 2002 оны мөнгө санхүүгийн бодлогын үр дүн байлаа. 2002 оны эцсийн байдлаар хэрэглээний барааны үнээр илэрхийлэгдсэн инфляци нь жилийн 1.6 хувьтай гарсан нь Монгол улсын эдийн засгийн шилжилт эхэлсэн 1991 оноос хойших инфляцийн хамгийн бага түвшин юм. Хэрэглээний барааны үнийн индекст өндөр хувийн жин эзэлдэг хүнсний барааны(50.8) бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар буурсан байна. Харин төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан банк хоорондын ханш 2001 оны эцсийн байдлаар 1102 төгрөгтэй байсан бол 2002 оны эцсийн байдлаар 1125 буюу төгрөгийн ханш энэ онд 2.1 хувиар суларсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Төгрөгийн евро (20.1%), иен (11.8%), юан (2.1%)-тай харьцах харьцах ханш тус тус суларсан бол рубльтэй харьцах ханш 2.2 хувиар чангарчээ.

Монголбанкны цэвэр гадаад нөөц 2002 оны эцсийн байдлаар 225.87 сая доллар байсан ба энэ нь 2001 оны мөн үеэс 65.86 сая долараар буюу 41.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэ нь манай улсын 17.8 долоо хоногийн импортын хэрэгцээг хангахаар байна.

1996-1999 онд болсон банкны хямралаас сургамж авсан банкуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд 2000 оноос тогтворжиж эхэлсэн бөгөөд 2002 оны эцсийн байдлаар банкуудын өөрсдөө чанаргүй хэмээн ангилсан зээлийн хэмжээ 16.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувь байгаа бөгөөд энэ хувь хэмжээ 2001 оныхоос 0.9 нэгжээр, 2000 оныхоос 16.7 нэгжээр буусан. Мөн банкуудын актив 2001 оноос 48.2 хувиар өсч, 493.0 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ний 40.1 хувь болж байна. Банкны зээл олголтын чанарын сайжралтаас үүдэн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн банкинд итгэх итгэл дээшилж хадгаламж, зээлийн хэмжээ өсөж Монголын банк санхүүгийн салбарын түүхэн дэхь хамгийн өндөр түвшинд 2002 оны эцсээр хүрсэн: 2002 оны 12 дугаар

сарын 31-ний өдрийн байдлаар банкин дахь аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж 282.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 61.5 хувиар өндөр байна. Хадгаламжийн нийт үлдэгдлийн 52.1 хувь нь төгрөгийн хадгаламж байгаа нь Төгрөгийн нэр хүнд иргэд, бизнес эрхлэгчдийн дунд дээшилж байгаагийн гэрчилгээ. Банкуудын зээл ч мөн 71.4 хувиар өсч 231.4 тэрбум төгрөг болохдоо төгрөгийн зээлийн өсөлт 69.7(%), валютын зээлийх 74.1(%) байсан нь төгрөгийн ханшийн тогтворжилттой шууд холбоотой. Банкнаас гадуурхи мөнгөний нийт мөнгөнд (M2) эзлэх хувь хамгийн өндөр түвшиндээ (39.6%) 1999 онд хүрснээ буурах хандлага ажиглагдаж энэ үзүүлэлт 2002 онд 25.7 хувь буюу 2000 оныхоос 13.3, 2001 оныхоос 7.3 нэгжээр буурчээ.

Мөн энэ онд 38 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) шинээр байгуулагдаж, 2002 оны эцэс гэхэд нийт 64 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдсэн дүнгээр ББСБ-уудын нийт зээл 2002 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 7 дахин өсч 31.0 тэрбум төгрөгт хүрчээ. Банкнаас гадуурхи бэлэн мөнгөний хувь хэмжээ буурч их хэмжээний эх үүсвэр дотооддоо банк, ББСБ-д төвлөрөн эргээд иргэд, бизнес эрхлэгчдэд зээл, хөрөнгө оруулалтын хэлбэрээр очих ажиллагааг санхүүгийн зуучлал гэдэг бөгөөд 2002 оны хувьд дээрхи зуучлал ихээхэн гүнзгийрч хөгжлөө /хавсралт хүснэгтийг үзэх/. Санхүүгийн зуучлалын хэмжээ, цар хүрээг илтгэх гол үзүүлэлт болох нийт мөнгө буюу M2/ДНБ-ний харьцаа 2000 онд 24.8 хувь, 2001 онд 29.3 хувь, 2002 онд 38.2 хувь хүрлээ.

Банкны зээлийн эргэн төлөлт эрс сайжирсанг дараахь үндсэн 4 шалтгаанаар тайлбарлаж болно. Үүнд: нэгдүгээрт, эдийн засгийн макро орчин тогтвортой намжмал байсан, хоёрдугаарт, банкуудын зээл олгох ур чадвар дээшилж туршлагажсан, гуравдугаарт, тодорхой эрхэлсэн бизнестэй, тогтмол орлогын эх үүсвэртэй, барьцаа хөрөнгө бүхий зээлдэгчдийн давхраа Монголд бий болсон, дөрөвдүгээрт, Монголбанкнаас банкуудад тавих хяналт, хийх шалгалт тухайн банкуудын үйл ажиллагаанд оршиж болох эрсдлийг тооцон дүгнэн цэгнэх, удирдах чиглэлийг илүүтэйгээр баримтлах болсон зэрэг болно.

Дампуурсан банкуудын найдваргүй зээлийн оронд Засгийн газраас гаргасан өрийн бичиг болох банкны бүтцийн өөрчлөлтийн бондыг (ББӨБ) төлж барагдуулах чиглэлээр онцгой ахиц 2002 онд гарлаа. 2001 онд нийт 6.3 тэрбум төгрөгийн ББӨБ-г төлсөний 6.0 тэрбум төгрөг нь Монголбанкинд, 0.3 тэрбум төгрөг нь Хадгаламж банкинд оногдсон бол 2002 онд нийт 13.6 тэрбум төгрөгийн ББӨБ төлөгдсөнөөс 13.6 тэрбум төгрөг нь Монголбанкинд хийгдсэн байна. Ингэснээр Монголбанкны тэнцэл дэхь банкны бүтцийн өөрчлөлтийн бондын төлбөрийг Санхүү эдийн засгийн яам барагдуулж дуусгавар болгов.

Дампуураад байсан ХААН банкны үйл ажиллагаа 2001 оноос тогтворжиж богинохон хугацаанд менежмент сайтай, нэр хүндтэй, томоохон банкны нэг боллоо. Нийт банкуудын дунд 2002 оны эцсийн байдлаар ХААН банк 2.0 тэрбум төгрөгийн ашигтайгаар хоёрт орж нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувийн жин 0.8 хувь байна. Хөдөөд гарцтай банкуудын тоо ХАС банкаар нэмэгдэж орон нутагт тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгох асуудал хэвийн болсон.

1996 оны банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үр дүнд дан ганц бүтцийн өөрчлөлтийн бондоор өөрийн активын удирдлагыг эхэлсэн Хадгаламжийн банк бие даасан арилжааны ажиллагаа явуулах цар хүрээгээ 2002 онд өргөжүүлсний дүнд зээлийн багц нь 100 хувийн эргэн төлөлттэйгээр 7 тэрбум төгрөгт хүрч 731 сая төгрөгийн ашигтай ажиллаж анх удаагаа улсын төсөвт орлогын албан татвар төллөө.

Өнгөрсөн жил Капитрон банк интернет банк, Голомт банк телефон банк, интернет банк зэрэг санхүүгийн шинэ үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн ба 2001 онд анх шинээр нэвтэрсэн бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэр болох MASTER болон VISA карт, үүнийг дагалдсан үйлчилгээ нь тогтмолжиж, хамрах хүрээ, хэрэглэгчийн тоо нь эрс нэмэгдсэн байна. 2001 онд Голомт банк анх удаа эдгээр картуудыг гаргасан бол 2002 онд Худалдаа Хөгжлийн банк дотоодын болон гадаадын VISA картын үйлчилгээг хийж эхэлсэн. 2001 оны эцсийн байдлаар ХХБ-ны карт эзэмшигчийн тоо ердөө 3000 орчим байсан бол 2002 оны эцэс гэхэд Улаанбаатар

хотод 10000, Орхон аймагт 6000 хэрэглэгчтэй болжээ. Хөдөөгийн болон орлого багатай зээлдэгчдэд зориулсан зээлийн шинэ бүтээгдэхүүнийг манай хэд хэдэн банк өнгөрсөн онд нэвтрүүлсэн.

Эдийн засаг дахь мөнгөний зохистой хэмжээг Монголбанк удирдан зохицуулахдаа гол төлөв нөөц мөнгөний хэмжээг Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаагаар зохицуулж ирлээ. Монголбанк 2002 онд 1 триллион төгрөгийн ТБҮЦ гаргасан бөгөөд 833.4 тэрбум төгрөгийн ТБҮЦ борлогдсон байна. 2002 онд ТБҮЦ-ны хүүнд Монголбанк 3.9 тэрбум төгрөг төлжээ. 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкууд 61.0 тэрбум төгрөгийн ТБҮЦ эзэмшиж байна. Нөөц мөнгийг төлөвлөх, түүнд өөрчлөлт гаргадаг алт, валютын арилжааны мэдээллийг цуглуулах, зохицуулах чиглэлээр тодорхой алхмуудыг Монголбанк 2002 онд авч хэрэгжүүлэв. 2001 онд репо3 ба урвуу репо хэлцлийг Монголбанк банкуудтай хийдэг байсан бол 2002 оны 7 дугаар сарын 17-ны өдөр "Буцаан худалдан авах ерөнхий гэрээ" буюу репо хэлцлийн журамд банкууд нэгдсэнээр банк хоорондын хэлцлүүд боломжтой болсон юм.

Мөнгөний зах зээл дээр арилжаалагддаг үнэт цаасыг хямдруулан зарж, эргүүлэн худалдаж авах хугацаа, үнийг нэгэн зэрэг тохирдог энэхүү репо хэлцлийн гэрээ нь орчин үед түгээмэл хэрэглэгдэж байгаа мөнгөний бодлогын хэрэгсэл юм. Банкууд өөр хоорондоо банк хоорондын төгрөгийн зах, ТБҮЦ-ны хоёрдогч арилжааны нэг сарын хэмжээ 2002 оны 11 дүгээр сарын байдлаар 30 тэрбум төгрөгт хүрсэн нь ТБҮЦ-ны хоёрдогч зах зээл амжилттай хөгжиж байгааг илтгэнэ.

2002 оны банкны салбарын өмчлөлийн хамгийн том өөрчлөлтөөр Худалдаа Хөгжлийн банкны төрийн өмчийн 76 хувийг 2002 оны 6 дугаар сард Швейцарийн "Банка Коммерсиалле Лугано" болон АНУ-ын "Жералд Металс" компанийн хамтарсан консерциумд 12.23 сая ам.доллараар хувьчиллаа. Хувьчлагдсан ХХБанкны менежментийг Нидерландын "ING" группээс хийх нь Монголын банкны салбарт шинэ үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүн нэвтрэхэд тус нэмэр болох нь дамжиггүй.

2002 онд Монголбанкны гадаад харилцааны хувьд үйл явдал арвинтай он байлаа: 2002 оны 6 дугаар сард Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын Ерөнхийлөгч нарын XXXVII уулзалт Улаанбаатар хотод болж өнгөрлөө. Уг хурал нь "Даяарчлалын орчинд эдийн засаг, санхүүгийн сэргэх чадварыг хөгжүүлэх" сэдвийн дор явагдаж нийт гишүүн ба ажиглагч гишүүн нийт 15 орны төлөөлөгчид оролцлоо. Мөн 2002 оны 10 дугаар сард Москва хотод төвтэй ЭЗХАОУБ (МБЭС)-ийн зөвлөлийн 99, ОУХОБ (МИБ)-ын зөвлөлийн 76 дугаар хуралдаан Улаанбаатар хотод явагдлаа. 2002 онд Монголбанк дэлхийн санхүүгийн төв болох Лондон хотод өөрийн суурин төлөөлөгчийн газрыг нээн ажилуулсан.

2002 оны 6 дугаар сараас эхлэн Герман улсад дэлхийн стандартын хэмжээнд хүрэхүйц нууцлал, загвартай 10 000 төгрөгийн дэвсгэртийг Монголбанк шинээр гүйлгээнд гарлаа. Бий болсон мөнгө, санхүүгийн тогтвортой байдлыг бататган гүнзгийрүүлэх, санхүүгийн зуучлалыг улам эрчимтэй 2003 онд хөгжүүлэх зорилтыг тавин Монголбанк ажиллаж байна.

МОНГОЛБАНК